


БАТЛАВ:
ЗАСАГ ДАРГА.  О. УУГАНБААТАР

БАЯНЖАРГАЛАН СУМЫН ОНХС-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2024 ОНД
ХИЙГДЭХ "БЭЛЧЭЭРИЙН УСАН ХАНГАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ГҮНИЙ
ХУДГИЙН 4 ЦООНОГ ГАРГАХ" АЖЛЫН ДААЛГАВАР

2024 -03 -25.

Аргатай.

1	Төсөл боловсруулах үндэслэл	Сумын ИТХ-ын 2023 оны 12 дугаар сарын 19 ны өдрийн хуралдааны 18 дугаар тогтоолын хавсралтын 3.1.2 дахь заалт
2	Барилгын ажлын нэр /төрөл/ байршил	"Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах гүний худгийн 4 цооног гаргах ажил", Инженерийн өрөмдлөгийн ажил хийх газрын координатыг тодорхойлж зааж өгнө.
3	Ажлын хэмжээ зориулалт	Шилийн гол, Энгэр-Ус багийн нутаг дэвсгэрт бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зориулалтаар 4 ш (дөрөв) гүний худгийн цооног гаргана.
4	Төслийн захиалагч	Дундговь аймгийн Баянжаргалан сумын ЗДТГ
5	Ажиллах горим	Өдөрт 12 цагаас багагүй
6	Төслийн хүрээнд хийгдвэл зохих ажлын бүтэц	Гүйцэтгэгч ААН өөрийн зардлаар гидрогеологийн хайгуул хийж өрөмдлөг хийх уст цэгийг тодорхойлно. Энэ тухай акт, холбогдох баримтыг хөтөлж, бүрдүүлнэ. Захиалагч хайгуул, өрөмдлөг хийх зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авна. Худгийн цооногийн хийц, зохиомжийг MNS6088-2010 стандартын шаардлагад нийцүүлэн хийх бөгөөд өрөмдлөгийн ажлыг 224 мм-ээс багагүй диаметртэйгээр өрөмдөж, суултын, шүүрийн болон, ус дамжуулах янданг бүрэн, гүйцэт, нуралт үүсэхгүй байхаар тооцож төмөр хийцтэй янданг сонгож суулгана. Өрөмдлөгийн ажлын дараахь шахалтын ажлын үр дүнгээр худгийн усны ашиглалтын ундарга 1 л/с-ээс багагүй байна. Цооногийн суултын, ус дамжуулах яндан нь хэрэглэгдэхэд зөвшөөрөгдсөн ган хоолой байна. Ус өргөх яндан 32 мм-ээс багагүй диаметртэй, хүйтний улиралд зохицсон байна. Цооногийн хийц зохиомж нь түүнийг ашиглах ба сэргээн засварлахад төвөгтэй биш байна. Цооногийн шавхалт, цэвэрлэлтийн хугацаа 8 цагаас багагүй байх бөгөөд ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ. Цахилгааны эх үүсгэвэрт холбох кабел утсыг шийдвэрлэж